



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 281

Улаанбаатар хот

Хорооны 2012 оны 34 дүгээр тогтоолоор  
батлагдсан журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Компанийн тухай хуулийн 65.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 34 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх тухай” журам”-ын 3 дугаар зүйлд доор дурьдсан агуулгатай 3.13 дахь заалтыг нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 13 дахь заалт:

“3.13. Энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.6, 2.10, 2.11, 2.12, 3 дугаар зүйлийн 3.1, 3.10 дахь заалт хаалттай хувьцаат компанид хамаарахгүй.”

2. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын “болон” гэсний дараа “нээлттэй хувьцаат компанийн хувьд” гэж, мөн зүйлийн 3.8 дахь заалтын “хойшлуулна.” гэсний дараа “Нээлттэй хувьцаат компанийн хувьд” гэж тус тус нэмсүгэй.

3. Мөн журмын 3 дугаар зүйлийн 3.6 дахь заалтыг дор дурьдснаар өөрчлөн найруулсугай:

“3.6 Хурал зарлагч этгээд нь энэхүү журмын 2.5-т заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдөр гэдэгт энэхүү журмын 3.3-т заасны дагуу хурлын зарыг нийтэд мэдээлсэн өдрийг тооцно.”

4. Журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулж, олон нийтэд сурталчилж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын Алба /Х.Бум-Эрдэнэ/-нд тус тус даалгасугай.



ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

000455